Нэхэмжлэгч Д.Гантөмөр, Э.Бямба, Д.Батдэлгэр нар нь Налайх, Багахангай дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст холбогдуулан Д.Гантөмөрийн өмчлөлийн Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хулан хотхон 39/1 дүгээр байрны 9 тоот 2 өрөө орон сууцыг битүүмжилсэн шийдвэр гүйцэтгэгчийн 2023.07.22-ны өдрийн 25 дугаар тогтоол, шийдвэр гүйцэтгэгчийн эд хөрөнгө хураах тухай 2024.06.11-ний өдрийн 21310066/31 дугаар тогтоолыг,

Э.Бямбын өмчлөлийн Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хулан хотхон 39/1 дүгээр байрны 8 тоот 2 өрөө орон сууцыг битүүмжилсэн шийдвэр гүйцэтгэгчийн 2023.08.01-ний өдрийн 27 дугаар тогтоол, шийдвэр гүйцэтгэгчийн эд хөрөнгө хураах тухай 2024.06.11-ний өдрийн 21310066/30 дугаар тогтоолыг,

Д.Батдэлгэрийн өмчлөлийн Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хулан хотхон 39/1 дүгээр байрны 2 тоот 2 өрөө орон сууцыг битүүмжилсэн шийдвэр гүйцэтгэгчийн 2023.07.31-ний өдрийн 26 дугаар тогтоол, шийдвэр гүйцэтгэгчийн хөрөнгө хураах тухай 2024.06.11-ний өдрийн 21310066/29 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож, төлбөр төлөгч Сүккистар Тур ХХК-ийн төлбөрт битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалтаас дээрх орон сууцуудыг хасч, чөлөөлөхийг хариуцагчид даалгах тухай нэхэмжлэл гаргасныг хариуцагч эс зөвшөөрч, маргажээ.